



БЭЛЧЭЭР, ТАРИАЛАНГИЙН ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ХАРИЛЦАА, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

П.Содгэрэл*, А.Нарантуяа

Агроэкологи бизнесийн сургууль, ХААИС, Дархан-Уул аймаг, Монгол Улс

*Холбоо барих хаяг: sodgerel@sab.edu.mn

ХУРААНГУЙ

Газар тариалангийн харилцааны хууль эрх зүйн хэм хэмжээг Тариалангийн тухай хуулиар зохицуулахаар тусгаж өгсөн байна. Гэвч хуулийн хэрэгжилтийг хангахад малчид тариаланчдын хооронд зөрчил, маргаан их үүсдэгээс хэрэгжилт хангалтгүй байна. Энэ судалгаагаар хуулийн хэрэгжилтийг хангахад гарах үр дагавар түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах арга хэмжээг санал болгов. Судалгааны үр дүнгээр Дархан-Уул аймгийн хэмжээнд тариалангийн талбайнууд нь байрилын хувьд хэт нэг дор бөөгнөрсөн, 200 га-аас их хэмжээгээр хагалсан зэрэг нь ландшафтын тэсвэртэй байх зүй тогтлыг алдагдуулах төлөвтэй байна. Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зарим заалтууд тухайлбал: 24.2, 24.4 нь малчид, тариаланчдын хооронд зөрчил үүсэх хандлагатай байна. Иймд экологижсон, дасан зохицсон газар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь чухал байна.

ТҮЛХҮҮР ҮГС: Хуулийн хэрэгжилт, малчид, тариаланчид, тэнцвэртэй ашиглалт

ОРШИЛ

Манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр хүн амын төвлөрөл ихээхэн эрчимжиж, тэр тусмаа томоохон төв суурин газруудын ойролцоох нутагт хүн, мал хэт бөөгнөрч нутаг дэвсгэрийн ачаалал ихэсч, байгалийн ландшафтын төрх байдал өөрчлөгдсөөр байна. Нөгөө талаар газар ашиглалтын зориулалт нэмэгдэхийн хэрээр газрын бүтэц харьцаа, тэдгээрийн ашиглалтын хэмнэлд өөрчлөлт гарч, экологийн тэнцвэрт байдал алдагдах нөхцлийг буй болгож байна. Ялангуяа байгаль орчны ерөнхий доройтол, уур амьсгалын огцом өөрчлөлт, хүний аж ахуйн түрэмгий үйл ажиллагаанаас хамааран хөрсний үржил шимийн доройтол, элэгдэл эвдрэл түүхийн дунджаас 300 дахин, сүүлийн 300 жилийн дунджаас 3 дахин, биологийн төрөл зүйл

цөөрөх нь түүхийн дунджаас 1000 дахин эрчимтэй явагдаж байна [3]. Тариалан эрхлэх, тариалангийн бүс нутгийг тогтоох, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг хамгаалах, сайжруулах, тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах үүднээс 2016 онд Тариалангийн тухай хуулийг баталсан байдаг. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх боломжит нөхцлийг санал болгосноор малчид, тариаланчдын эрх ашиг, зөрчлийг зохицуулах боломж бүрдэх юм. Иймд Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад гарах үр дагаврыг тогтоож, шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь чухал байна.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА


Судалгааг суурин аргаар холбогдох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн болон газар ашиглалтын талаархи мэдээ материалуудыг цуглуулж эх материал судлах, харьцуулах, түүнд

газарзүйн мэдээллийн системийн орон зайн дүн шинжилгээний аргаар боловсруулалт хийх замаар зураглал гаргахад ашигласан болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дархан-Уул аймгийн ХАА-н газрын ашиглалтын байдал: Аймгийн нийт газар нутгийн 54,1 хувийг бэлчээр, 10,6 хувийг тариалангийн газар тус тус эзэлдэг. Гэвч сүүлийн

10 жилд бэлчээрийн талбайн хэмжээ 5,8 %-иар багасч, тариалангийн талбайн хэмжээ 4,5 %-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна [7] (1-р зураг).



1-р зураг. Дархан-Уул аймгийн бэлчээр, тариалангийн газрын өөрчлөлт

Дээрх өөрчлөлтийн зүй тогтол нь цаашид ч хэвээр хадгалагдах магадлалтай. Учир нь улсын болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагаас үүдэн аливаа зориулалтаар газар шинээр олгогдох бүрт гол төлөв ХАА-н газраас, ялангуяа бэлчээрийн талбайгаас шилжигдэж байдаг. Тухайлбал: уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлал, барилга байгууламж гэх мэт. Ингэснээр хагалсан талбайн хэмжээ нэмэгдэж, байгалийн ургамлан бүрхэвч бүхий бэлчээрийн талбай багасах замаар ландшафтын тэсвэртэй

байх зүй тогтлыг алдагдуулахад хүрч байна. Агрolandшафт нь хэдий чинээ олон төрлийн, нийлмэл бүтэцтэй байх тусам төдий чинээ гадны янз бүрийн нөлөөнд тэсвэртэй, тогтвортой байдаг байна [2,3,4]. Гэтэл тус аймгийн тариалангийн талбайнууд нь байршлын хувьд 1 дор хэт их бөөгнөрсөн, 70 нэгж талбар 200 га-аас дээш талбайтай байгаа нь аж ахуйн хувьд ач холбогдолтой ч экологийн тогтвортой бус нөхцлийг бий болгохуйц байдалтай байна (2-р зураг).



2-р зураг. Дархан-Уул аймгийн тариалангийн газар, 200 га-аас их хэмжээтэй талбайн байршилт

Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн шинжилгээ: Уг хуулийн 24.2-т “Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно” гэж заасан бөгөөд энэхүү заалтыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор 28.1.10-т тусгагдсан байдаг. Эдгээр заалтын хэрэгжилтийг хангах явцад тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд 216 өвөлжөө, хаваржааны эзэмшил газар хамрагдаж, 41926 га талбай бэлчээрээс хасагдах тооцоо гарч байна (3-р зураг).



3-р зураг. Хуулиар хориглох зурвасд хамрагдаж буй өвөлжөө, хаваржаа

Дархан-уул аймгийн хэмжээнд бэлчээрийн талбай жил бүр багасч, тэжээлийн нөөц төдий хэмжээгээр буурч байгаагаас бэлчээрийн хүрэлцээ хангамж, даац 3,7 дахин хэтэрсэн

байна. Гэвч уг хуулийн 24,2 заалтыг хэрэгжүүлбэл нэгэнт хүрэлцээгүй байгаа бэлчээрийн талбайгаас 2 дахин багасах нөхцөл бүрдэж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1.

Бэлчээрийн даацын тооцоо

№	Үзүүлэлтүүд	Аймгийн хэмжээгээр		
		2014 он	2015 он	Тариалангийн хуулийн 24.2-р заалтын хэрэгжилтийн үр дүнгээр
1.	Бэлчээрийн талбай /га/	219069.2	178001.5	106820.8
2.	Га –гийн ургацын хэмжээ /цн,га/	5.3	5.3	5.3
3.	Бэлчээрийн нийт нөөц /цн/	1645249	943408	566150
4.	Нэг хонин толгойн жилд хэрэглэх өвсний хэмжээ, цн	6,02	6,02	6,02
5.	Бэлчээрийн даац, /хонин толгой/	273297	156712	94045
6.	Бэлчээрт буй малын тоо /хонин толгой/	579149	588130	588130
7.	Бэлчээрийн хүрэлцээ, хангамж /+, -/	-305851.9	-431417.7	-494085.1
8.	Бэлчээрийн ачаалал хэтэрсэн байдал	2.1	3.7	6.2

Тариалангийн тухай хуулийн дээрх заалтуудын хэрэгжилтийг хангах явцад дараах үр дагаврууд

бий болох юм. Үүнд: Тариалангийн тухай хуулийн дээрх заалтуудын хэрэгжилтийг хангах

явцад дараах үр дагаврууд бий болохоор харагдаж байна. Үүнд:

1. Талбайн гадна захаас 500м зурвас газарт мал, амьтан бэлчээрлүүлэхгүй, хамрагдах өвөлжөө хаваржаа бүхий малчдыг нүүлгэн шилжүүлснээр газар тариалан эрхлэгчдэд сайн талтай ч энэ нь малын тоо толгой өсөн нэмэгдэж даац хэтрэлттэй ашиглаж байгаа өнөөгийн нөхцөлд бэлчээрийн доройтох хэлбэрийг эрчимжүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлөх шалтгаан болох юм.

2. Малчид үе дамжин нутаглаж ирсэн өвөлжөө, хаваржааны газраасаа нүүх нь тэдний сэтгэл зүйд нөлөөлж, малчид тариаланчдын хооронд үл ойлголцох нөхцөл бий болох магадлалтай

3. Тариалангийн талбайн захаас 100м зурвас газар нь уг хуулийн 11.1, 11.2-т заасны дагуу тариалангийн газарт шилжиж, хагалсан талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. Ингэснээр ландшафтын зохистой байх эдэлбэрийн харьцаанд тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарна.

4. Талбайн захаас 500 метрийн зурвасаас 100 метр нь хуулийн 11.2-т заасан үндэслэлээр эргэлтийн талбайн эзэмшил ашиглалтан хамаарч байгаа боловч үлдсэн 400м зурвас бүхий газар бэлчээрээс хасагдаж ГНС-ийн аль ангилалд хамаарах нь тодорхойгүй болж байна.

Иймээс Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг зүй зохистой хангах хүрээнд

дараах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохилтой гэж үзлээ.

Агро-ойжуулалтын арга гэдэг нь тухайн талбайд мод эсвэл бут сөөгийг үр тариатай хамтатган тариалж, МАА-н үйлдвэрлэлтэй хослуулан эрхэлдэг газрын менежментийн систем юм [6]. Агро-ойжуулалтын систем бол хөрсний элэгдлийг сааруулах, цөлжилтийг бууруулах, хөрс усыг хамгаалах, ХАА-н үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, модны гаралтай байгалийн баялгийг олборлож аж ахуйн орлогыг дээшлүүлэх үүднээс тариалангийн талбай, МАА-н ферм болох бэлчээрийн газарт эсвэл тэдгээрийг тойруулан зориудаар мод тарьж ургуулах олон талт арга хэмжээ багтдаг [6]. Дархан-Уулаймгийн ХАА-н гол эдэлбэрүүд болох тариалан, хадлан, бэлчээрийн талбайн бүтэц харьцаа нь экологийн тогтвортой байдлын хувьд “дунд зэрэг тогтвортой” гэсэн үзүүлэлттэй гарч байна.

Иймд тариалангийн хуулийг хэрэгжүүлэх бүс газарт ойн зурвас тариалах, таримал хадлан бий болгох зэргээр ашиглах асуудлыг төлөвлөж зохион байгуулснаар ойн зурвасыг 2728 хүртэл га, таримал хадланг 68452,5 хүртэл га талбайгаар тус тус нэмэгдүүлж, газар ашиглалтын тогтвортой байдлыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх тооцоо гарч байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2.

Дархан-Уул аймгийн газар ашиглалтын тогтвортой байдал

№	Эдэлбэрийн төрөл	K ₁ ¹	Газрын нэгдмэл сангийн Тариалангийн хуулийн тайлангийн дүнгээр /2015 он/ хэрэгжилтийн үр дүнгээр			
			Талбай P _i , га	K _{1i} P _i	Талбай P _i , га	K _{1i} P _i
1	Тариалангийн газар	0.14	33758.94	4726.252	33758.94	4726.252
2	Ойн зурвас	1	-	-	2728.6	2728.6
3	Хадлангийн талбай	0.68	9072.5	6169.3	77525	52717
4	Бэлчээрийн газар	0.62	178001.48	110360.9	106820.80	66228.9
K _{ЭТБ} ²			0.549086926		0.572380727	
			Дунд зэрэг тогтвортой		Дунд зэрэг тогтвортой	

¹ – Засварын итгэлцүүр [5].

² – Газар ашиглалтын тогтвортой байдлын коэффициент.

Хэрэв **КЭТБ** нь 0,33-аас бага байвал нутаг дэвсгэр экологийн хувьд тогтворгүй, 0,34-0,50 хүртэл бол бага, 0,51-0,66 хүртэл байвал дунд зэрэг, 0,67-аас их байвал нутаг дэвсгэр экологийн хувьд тогтвортой байна гэж үзнэ [5]. Дээрх хэмжээний таримал хадлан бий болгосноор ургац болон малын тэжээлийн нөөцийн хэмжээг 205 000 тонноор нэмэгдүүлээд зогсохгүй байгалийн эрсдлээс хамгаалагдах нөхцөл бүрдэх, малчид тариаланчдын эрх ашиг харилцан хамгаалагдах болно.

1. Тариалангийн хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хуулийн хориглох заалт бүхий зурваст хамрагдсан өвөлжөө, хаваржаа бүхий малчдыг

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Агроландшафт нь хэдий чинээ олон төрлийн, нийлмэл бүтэцтэй, 200 га-гаас бага байх тусам төдий чинээ гадны янз бүрийн нөлөөнд гэсвэртэй, тогтвортой байдаг[2,5]. А.С.Чеканышкины “150-200 га талбайг хагалж эзэмшвэл биологийн зохицуулах механизм сул илрэх тул ийм хэмжээний талбайг нэг дор хагалахаас зайлсхийх хэрэгтэй” гэсэн шинжлэх

ДҮГНЭЛТ

1. Дархан-Уул аймгийн бэлчээрийн талбайн хэмжээ 5,8 %-иар багасч, тариалангийн талбайн хэмжээ 4,5 %-иар нэмэгдэж байгаа нь цаашид ч үргэлжлэх болно. Мөн тариалангийн талбай нь хэт бөөгнөрөн байрласан, нэг дор том хэмжээний талбай хагалсан нь ландшафтын гэсвэртэй байх зүй тогтлыг галдагдуулах төлөвтэй байна.

2. Тариалангийн тухай хуулийн хэрэгжүүлэх хүрээнд 41926 га талбай бэлчээрээс хасагдаж газрын нэгдмэл сангийн аль ангилалд хамаарах нь тодорхойгүй байна. Мөн 216 өвөлжөө, хаваржааны эзэмшил газар хориглох заалтанд хамрагдаж бэлчээрийн даацыг 2 дахин нэмэгдүүлж, малчид тариаланчдын хооронд зөрчилдөөн үүсэх нөхцөл бүрдэж байна.

3. Зөвхөн тухайн тариалангийн талбай экологийн нөхцлийг сайжруулах гэж оролдох нь

НОМ ЗҮЙ

1. Геоэкологийн хүрээлэн. (2008). Газар ашиглалтын онол арга зүйн асуудлууд. УБ.
2. Мижиддорж. Ж. (2010). Тариаланг экологижуулж, дасан зохицох чадварыг дээшлүүлэх технологийн үндэс. УБ.
3. Мижиддорж. Ж. (2013). Агроэкологи. УБ.

хуулийн 24.4-т заасны дагуу нүүлгэн шилжүүлэх газрыг дахин төлөвлөж, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжилтийг үе шаттай зохион байгуулах шаардлагатай.

2. Мөн уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд үлдсэн 400м зурваст хамаарах газрыг хэний эзэмшил, ашиглалт, ямар ангиллын газарт хамаарах талаар эрх зүйн үндэслэл байхгүй байгаа тул холбогдох журмыг боловсруулж, ГНС-ийн дэд ангилалд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

ухааны тодорхойлолтод нийцэхгүй байна. Дархан-Уул аймгийн хэмжээнд олон төрлийн эдэлбэрүүд байгаа хэдий ч тариалангийн талбайнууд нь томоохон хөндийд бөөн байдлаар оршиж, нэлээдгүй талбай 200 га-аас их талбайтай байгаа нь экологийн тогтвортой бус нөхцлийг бий болгохуйц байдалтай байна.

эрсдэл ихтэй манай орны хувьд нэн хангалтгүй тул тариалангийн талбай, бэлчээрийн зохистой харьцааг хадгалсан экологижсон газар зохион байгуулалтын ажлыг нэн богино хугацаанд хийх шаардлагатай байна. Дархан-Уул аймгийн хэмжээнд экологийн хувьд тогтвортой эдэлбэрүүд болох ойн зурвас 2728 хүртэл га, таримал хадлан 68452,5 хүртэл га талбайгаар тус тус нэмэгдүүлэх боломжтой.

4. Тааламжтай бүс бүхий газар ашиглалтын төрлийн хэмжээ нэмэгдсэнээр хөрсний эвдрэлийн үйл явц ба гангийн эсрэг нөлөөллийн бууралт, хөрсний үржил шимийн дээшлэлт, намагжих боломжгүй болох, тогтвортой бүтээгдэхүүн авах зэрэг эерэг үр дагавар бий болно.

4. Волков. С.Н. (1998). Землеустройство в условиях земельной реформы. Москва.
5. Умберто Бланко, Р. Л. (2011). Хөрс хамгаалал ба менежментийн зарчим. УБ.
6. Дархан-Уул аймгийн газрын нэгдмэл сангийн тайлан.(2006-2015)
7. Тариалангийн тухай хууль.(2016)

SOME REGULATION OF AGRICULTURAL LAND USE AND REGULATORY ARRANGEMENTS

P.Sodgerel* and A.Narantuya

School of Agroecology and Business, Mongolian University of Life Sciences, Darkhan-Uul aimag, Mongolia

*Corresponding author: sodgerel@sab.edu.mn

ABSTRACT

Legislation on cropping is to regulate the relations pertaining to the cultivation, establishment of crop areas, rational use of farms, protection of soil and improvement of crop and intensive livestock production. However, there is a lack of enforcement and lead to disagree with crop and herder farmers. In this study, the consequences of enforcing the law were to suggest a scientifically-oriented approach. According to the results of the survey, crop farms in Darkhan-Uul aimag are crowded in one place and over 200 hectares are expected to undermine the stability of the landscape. Some provisions for the implementation of the Law on Crops are: 24.2 and 24.4 tend to conflict with herders and farmers. Consequently, ecologically and adapted land management measures are essential.

KEYWORDS: Law enforcement, herders and farmers, balanced use